



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 30 дугаар хуралдааны тэмдэглэлд:

XXX.72.ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 нэрийн, нийт 130,183,000.00 (нэг зуун гучин сая нэг зуун наян гурван мянган) төгрөгийн балансын үнэ, 59,976,503.97 (тавин есөн сая есөн зуун далан зургаан мянга таван зуун гурван төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг дэмжээд, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлэхийг даалгав.

Төрийн өмчөөс орон нутгийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх шийдвэр гарах хүртэл хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, гэрээгээр ашиглуулахыг “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газарт зөвшөөрөв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002393
30-р хуралдаан

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
... дугаар тэмдэглэлийн хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ШИЛЖүүлэх ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Зуух КВР, КВР-2.33 МВТ	10/1/2016	ш	1	31,705,000.00	31,705,000.00	18,758,791.47	12,946,208.53	Хөвсгөл аймгийн Их-Уул сумын "Их-Уул дулаан" ХХК
2	Усан халаалтын зуух, 2.33 МВТ	5/1/2017	ш	1	54,555,000.00	54,555,000.00	15,229,937.50	39,325,062.50	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын "Эрчим-Хүч" ААТҮГ
3	Зуух КВР, КВР*2.33 МВТ	10/1/2016	ш	1	43,923,000.00	43,923,000.00	25,987,775.00	17,935,225.00	
НИЙТ ДҮН						130,183,000.00	59,976,503.97	70,206,496.03	
						(нэг зуун гучин сая нэг зуун наян гурван мянган)	(тавин есөн сая есөн зуун далан зургаан мянга таван зуун гурван төгрөг ерэн долоон мянган)	(далан сая хоёр зуун зургаан мянга дөрвөн зуун ерэн зургаан төгрөг гурван мянган)	